

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

(Бизнес эрхлэгчдэд зориулсан цуврал гарын авлага)



**Монголын гадаад худалдааны статистик
мэдээлэлийн шинжилгээ, дүгнэлт
(2003 оны II улирлын байдлаар)**

Улаанбаатар 2003

ГАРЧИГ

1.	Гадаад худалдааны 2003 оны II улирлын ерөнхий тойм	
2.	Нийт экспорт	4 – 6
2.1.	Экспортын барааны бүтэц	6 – 7
3.	Импорт	8 – 9
3.1.	Импортын барааны бүтэц	9 – 10
4.	Гадаад худалдааны газарзүйн байршил	
4.1.	Экспортын газарзүйн байршил	11 – 13
4.2.	Импортын газарзүйн байршил	13 – 16
4.3.	Импортын гол нэрийн барааны үнийн болон тоо хэмжээний индекс	17 – 18
5.	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифийн индекс	18
6.	Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн болон тоо хэмжээний индекс	19 – 21
7.	Гадаад худалдааны ерөнхий төлөв ба валютын ханш	21
8.	Гадаад худалдааны зохицуулалтууд	22 – 23
	• Импортын гаалийн татвар	24 – 26
	• Онцгой татвар	26 – 27
	• Экспортын гаалийн татвар	

1. Гадаад худалдааны 2003 оны эхний хагас жилийн ерөнхий тойм

2003 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 580.2 сая ам. доллар, үүнээс экспорт 219.3 сая ам. доллар, импорт 360.9 сая ам. доллар боллоо. Гадаад худалдааны тэнцэл 141.6 сая ам. долларын алдагдалтай гарсан байна. Нийт бараа эргэлт өнгөрсөн оны мөн үеэс 9.8 хувиар өссөний дотор импорт 19.4 хувиар өсч харин экспорт 3.0 хувиар буурчээ.

Экспортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоосны экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24.4 сая ам. доллараар, мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний экспорт 3.7 сая ам. доллараар, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэлийн экспорт 0.7 сая ам. доллараар тус тус буурсан нь экспорт дүнгээрээ буурахад голлон нөлөөлжээ. Харин нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 15.6 сая ам. доллараар, эрдэс бүтээгдэхүүний экспорт 2.1 сая ам. доллараар, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүний экспорт 1.3 сая ам. доллараар тус тус өссөн байна.

2. Нийт экспорт

Экспортод нийлүүлсэн барааны 76.9 хувийг валютын төлбөртэй худалдаагаар, 0.7 хувийг бараа солилцоогоор, 21.7 хувийг гадаадын захиалагчийн материалаар хийсэн бараа эзэлж .

Хүснэгт 1

Гадаад худалдааны бараа эргэлт (жил бүрийн эхний хагас жилийн байдлаар)

мян ам. доллар

Жил	2001	2002	2003
Нийт бараа эргэлт	475962. 3	528200. 1	580287. 6
Экспорт	196972. 2	226062. 7	219344. 3
Валютын төлбөртэй худалдаа	133540. 2	180430. 6	168759. 2
Бараа солилцоо	4980.1	15573.9	1592.2
Төлбөрт зориулсан бараа	2288.6	-	-
Гадаадын захиалагчийн материалаар хийсэн бараа	55695.0	28989.5	47499.8
Бусад	468.3	1068.7	1489.1
Импорт	278990. 1	302137. 4	360943. 3
Валютын төлбөртэй худалдаа	168123. 7	204277. 5	234271. 9
Бараа солилцоо	712.2	303.7	14.9
Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа	6780.7	15809.3	13237.8
Гадаадын тусламжийн бараа	36059.3	28914.7	29086.2
Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа	23017.4	11274.0	42754.5
Гадаадын захиалагчийн материал, эд зүйлс	43244.0	39802.0	39778.4
Бусад	1052.8	1756.2	1799.6

Эх үүсвэр: Статистикийн Ерөнхий Газрын мэдээ

Экспортод нийт 219.3 сая ам. долларын бараа гаргасан нь 2002 оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар буурсан байна. Энэ хугацаанд борлуулсан алтны хэмжээ 3118.6 кг-аар, үнийн дүн 24.4 сая ам. доллараар, түүнчлэн мах ба хүнсний дайвар бүтээгдэхүүний экспорт 3.4 сая ам. доллараар тус тус буурсан нь экспортын өөрчлөлтөд голлон нөлөөлсөн байна. Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 25.7 мянган тонноор, үнийн дүн нь 571.2 мянган ам. доллараар буурчээ. Түүнчлэн молибдены хүдэр, баяжмалын экспорт 1.3 сая ам. доллараар, эрдэс бүтээгдэхүүний экспорт 2.1 сая ам. доллараар өсчээ. Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, ширний экспорт 737.7 мянган ам. доллараар буурч, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 16.85 сая ам. доллараар нэмэгдсэн байна.

2.1 Экспортын барааны бүтэц

Экспортын барааны нийт дүнд эрдэс бүтээгдэхүүн 76.1 сая ам. доллар буюу 34.7 хувь, нэхмэл болон нэхмэлийн бүтээгдэхүүн 68.0 сая ам. доллар буюу 31.0 хувь, алт 40.5 сая ам. доллар буюу 18.5 хувь, амьд мал амьтад, мал амьтан ургамлын гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний бүтээгдэхүүн 7.0 сая ам. доллар буюу 3.2 хувь, арьс ширэн түүхий эд, боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн 22.0 сая ам. доллар буюу 10.0 хувийг тус тус эзэлж эдгээр нь нийт экспортын дүнгийн 97.4 хувийг эзэлж байна.

Экспорт, барааны бүлгээр, мянган ам. доллар
(жил бүрийн эхний хагас жилийн байдлаар)

Барааны бүлэг	2001	2002	2003
Нийт экспорт	196972. 2	226062. 7	219344. 3
Эрдэс бүтээгдэхүүн	98181.8	73956.5	76068.2
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	66420.3	51460.2	67996.5
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	15795.3	22698.5	21960.8
Мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн	5885.0	9666.7	5946.7
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	3247.6	1586.0	2849.5
Бусад	7442.2	1782.5	3975.0

Экспортолсон мөнгөжөөгүй алтны 33.8 хувийг АНУ-д, 25.4 хувийг Австралид, 25.3 хувийг Их Британид, 14.5 хувийг ОХУ-д, зэсийн баяжмалын 97.5 хувийг Хятадад, хайлуур жоншны баяжмалын 90.3 хувийг ОХУ-д, 9.7 хувийг Украинд, ямааны самнасан ноолуурын 34.0 хувийг Италид, 36.1 хувийг Хятадад, 15.0 хувийг Японд үхрийн мах, малын дайвар бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг ОХУ-д, боловсруулаагүй нефть, бодын шир болон богийн арьсны дийлэнхийг Хятадад, сүлжмэл буюу оёмол эдлэлийн ихэнхийг АНУ-д тус тус гаргажээ.

3. Нийт импорт

Импортоор нийт 360.9 сая ам. долларын бараа, түүхий эд оруулсан нь 2002 оны мөн үеэс 58.8 сая ам. доллараар буюу 19.5 хувиар өсөв.

2003 оны эхний хагас жилд өндөр хөгжилтэй 7 орны импорт өнгөрсөн оны мөн үеэс 48.1 хувиар, Европын Холбооны орнуудынх 77.0 хувиар, хөрш орнуудынх 9.5 хувиар тус тус өсчээ.

Импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийн импорт өнгөрсөн оны мөн үеэс 18.8 сая ам. доллараар, эрдэс бүтээгдэхүүн 14.8 сая ам. доллараар, авто, агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 14.4 сая ам. доллараар, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн 0.5 сая ам. доллараар, хими болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 4.3 сая ам. доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн 4.0 сая ам. доллараар, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 5.3 сая ам. доллараар тус тус өссөн нь импортын өсөлтөд голлон нөлөөлжээ. Харин ургамлын гаралтай бүтээгдэхүүний импорт 17.0 сая ам. доллараар буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төмс, сонгино, сармис, шар будаа, маргарин, хатуу чихэр, янжуур болон дүнсэн тамхи зэрэг бүтээгдэхүүн, автобензин, дизель түлш, онгоцны түлш, түлшний мазут зэрэг нефтийн бүтээгдэхүүн, азотын бордоо, эдийн саван, угаалгын нунтаг, органик хүхэрт нэгдэл, тунгаар савлагдсан эм, хуванцар шуудай болон уут, автобус, ачааны тэрэгний шинэ дугуй, нийлэг мяндсан даавуу, савхин түрүүтэй гутал, цонхны шил ган хоолой ба ган огтолбор, хана буюу цонхонд бэхлэх агааржуулагч төхөөрөмж, хэвлэлийн

машины туслах төхөөрөмж, ахуйн зориулалттай шахуургат хөргөгч, бульдозер, авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, экскаватор, ухах, өрөмдөх машин зэргийн эд анги, шороо, чулуу ялгах, холих машин, эрдэс бүтээгдэхүүнийг нунтаглах машины эд анги, нийтийн тээврийн хэрэгсэл, хөнгөн болон ачааны тэрэг зэрэг барааны импорт үнийн дүн болон биет хэмжээгээрээ тус тус өссөн байна.

Импортоор нийлүүлэгдсэн барааны 64.9 хувийг валютын төлбөртэй худалдаа, 3.7 хувийг бараа солилцоо, 5.2 хувийг гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, 8.0 хувийг гадаадын тусламжийн бараа, 11.8 хувийг гадаадын хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, 11.0 хувийг гадаадын захиалагчийн материал, эд зүйлс эзэлж байна.

Олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага , хандивлагч орны тусламжаар 29.1 сая ам. долларын бараа импортлосноос барааг гарал үүслийн орноор авч үзэхэд ОХУ-д 11.6 хувь, Францад 6.7 хувь, Японд 58.2 хувь тус тус ногдож байна.

3.1 Импортын барааны бүтэц

Импортоор нийлүүлэгдсэн барааны нийт дүнд машин механик, тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 81.7 сая ам. доллар буюу 22.6 хувь, эрдэс бүтээгдэхүүн 68.0 сая ам. доллар буюу 18.8 хувь, үүний дотор нефтийн бүтээгдэхүүн 60.7 сая ам. доллар буюу 89.2 хувь, ургамлын гаралтай бүтээгдэхүүн 17.6 сая ам. доллар буюу 4.9 хувь, хүнсний зүйлс 25.6 сая ам. доллар буюу 7.1 хувь, авто, агаарын тээврийн хэрэгслэл, тэдгээрийн эд анги 41.4 сая ам. доллар буюу 11.5 хувь, нэхмэл болон нэхмэлийн бүтээгдэхүүн 41.0 сая ам. доллар буюу 11.3 хувь, үндсэн

төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 17.6 сая ам. доллар буюу 4.9 хувь, химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 17.6 сая ам. доллар буюу 4.9 хувийг тус тус эзэлж эдгээр бүтээгдэхүүнд нийт дүнгийн 86.0 хувь ногдож байна.

Импорт, барааны бүлгээр, мянган ам. доллар
(жил бүрийн эхний хагас жилийн байдлаар)

Барааны бүлэг	2001	2002	2003
Нийт импорт	287990. 1	302137. 4	360943. 3
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг	48366.5	62911.4	81662.8
Эрдэс бүтээгдэхүүн	58464.5	53195.4	68042.8
Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	34652.8	27014.6	41399.5
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	42495.3	40481.1	40983.0
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	17737.3	23022.5	25591.1
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	15346.2	13226.6	17560.8
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	11515.7	13665.0	17615.6
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	13701.7	34617.1	17642.6
Бусад	36710.1	34003.7	50445.1

4. Гадаад худалдааны газар зүйн байршил

4.1 Экспортын газар зүйн байршил

Манай улс дэлхийн 50 оронд бараа экспортлосноос Хятадад 49.1, ОХУ-д 8.0, АНУ-д 26.9, Австралид 4.7, Их Британид 5.8 хувь тус тус ногдож нийт экспортын 94.3 хувийг дээрхи орнууд эзэлж байна.

Экспорт орнуудаар:


/оны эхний хагас жилээр/

Д/ д	Улс	Экспортын үнийн дүн, мян. ам. доллар			Экспортод эзлэх хувийн жин %	
		2002	2003	Хувь	2002	2003
1.	Австри	9.5	1.5	15.8	0.0042	0.0007
2.	Бельги	136.0	190.9	140.4	0.0602	0.0870
3.	Болгар	0.5	2.5	500.0	0.0002	0.0011
4.	Хорват	0.0			0.0000	0.0000
5.	Чех улс	29.1	13.5	46.4	0.0129	0.0062
6.	Дани	0.0	0.0	0.0	0.0000	0.0000
7.	Финлянд	0.1	0.0	0.0	0.0000	0.0000
8.	Франц	16.7	88.1	527.5	0.0074	0.0402
9.	Герман	1225.2	1023.0	83.5	0.5420	0.4664
10.	Грек	0.0	0.0	0.0	0.0000	0.0000
11.	Унгар	0.0	11.1		0.0000	0.0051
12.	Ирланд	4.4	1.4	31.8	0.0019	0.0006
13.	Итали	4065.3	2649.7	65.2	1.7983	1.2080
14.	Нидерланд	856.3	512.0	59.8	0.3788	0.2334
15.	Норвеги	3.9	0.0	0.0	0.0017	0.0000
16.	Польш	4.9	1.6	32.7	0.0022	0.0007
17.	Португаль	0.0	0.0	0.0	0.0000	0.0000
18.	Румын	0.0	0.0	0.0	0.0000	0.0000
19.	ОХУ	16324.1	17574.0	107.7	7.2210	8.0121
20.	Словак	8.2	1.5	18.3	0.0036	0.0007
21.	Испани	99.0	30.1	30.4	0.0438	0.0137
22.	Швед	0.0	10.6		0.0000	0.0048
23.	Швейцари	8.8	91.9	1044.3	0.0039	0.0419

24.	Украйн	343.0	626.2	182.6	0.1517	0.2855
25.	Их Британи	3161.9	12288.8	388.7	1.3987	5.6025
26.	Югослав	0.0	0.0		0.0000	0.0000
27.	Афганистан				0.0000	0.0000
28.	Араб	0.0	60.5		0.0000	0.0276
29.	Хятад	99892.1	107717.3	107.8	44.1878	49.1088
32.	Хонконг	32.1	45.5	141.7	0.0142	0.0207
33.	Энэтхэг	0.0	0.0	53.7	0.0000	0.0000
34.	Япон	2387.6	2431.8	101.9	1.0562	1.1087
35.	Иордан		0.0	0.0	0.0000	0.0000
36.	Казахстан	513.3	16.4	3.2	0.2271	0.0075
37.	Киргизстан	0.0	0.0	0.0	0.0000	0.0000
38.	Хойд Солонгос	0.0	91.0		0.0000	0.0415
39.	Өмнөд Солонгос	9979.7	1096.1	11.0	4.4146	0.4997
40.	Кувейт				0.0000	0.0000
41.	Ливан	270.2	122.3	45.3	0.1195	0.0558
42.	Макао				0.0000	0.0000
43.	Балба	9.0	22.7	252.2	0.0040	0.0103
44.	Сингапур	52.2	394.7	756.1	0.0231	0.1799
45.	Тайван	1.4	2.4		0.0006	0.0011
46.	Турк	26.6	417.5	1569.5	0.0118	0.1903
47.	Туркменистан				0.0000	0.0000
48.	Узбекстан	13.5	0.0	0.0	0.0060	0.0000
49.	Вьетнам	23.5	15.7	66.8	0.0104	0.0072
51.	Нэгдсэн Арабийн Эмират Улс	0.0	60.5		0.0000	0.0276
52.	Канад	318.8	439.6	137.9	0.1410	0.2004
53.	Панам				0.0000	0.0000
54.	АНУ	76077.2	58931.5	77.5	33.6531	26.8671
55.	Австрали	9054.7	10290.6	113.6	4.0054	4.6915
56.	Шинэ Зеланд	0.0	0.0	0.0	0.0000	0.0000
	Нийт	226062.7	219344.3	97.0	100.00	100.00

Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий Газрын Статистикийн мэдээ

Гол экспортлогч орнуудыг графикаар харуулбал:



4.2. Импортын газар зүйн байршил

Манай улс 2003 оны эхний хагас жилд дэлхийн 69 орны бараа импортолсноос барааны гарал үүслийн орноор ОХУ 32.4, БНХАУ 20.7, Япон 10.2, БНСУ 8.1, ХБНГУ 4.7 хувийг тус тус эзэлж байгаа нь нийт импортын дүнгийн 76.1 хувь нь болов.

Импорт орнуудаар :


/эхний хагас жилийн байдлаар/

Улсуудын нэр	Импортын үнийн дүн, мян. ам. доллар			Импортод эзлэх %	
	2002	2003	хувь	2002	2003
1. Австри	231.2	3587.9	1551.9	0.0765	0.9940
2. Бельги	2087.2	3203.5	153.5	0.6908	0.8875
3. Болгар	296.1	515.9	174.2	0.0980	0.1429
4. Беларус	319.3	323.2	101.2	0.1057	0.0895
6. Чех	1687.5	2753.3	163.2	0.5585	0.7628
7. Дани	1298.9	876.4	67.5	0.4299	0.2428

8. Эстон	10.1	0	0	0.0033	0.0000
9. Финлянд	1419.3	1017.9	71.7	0.4698	0.2820
10.Франц	1381.6	4967.8	359.6	0.4573	1.3763
11.Герман	12695.9	17106.3	134.7	4.2020	4.7393
12.Грек	36.6	80.9	221	0.0121	0.0224
13.Унгар	779	1918.8	246.3	0.2578	0.5316
14.Ирланд	21.4	8.7	40.7	0.0071	0.0024
15.Итали	1521.1	1566.9	103	0.5034	0.4341
16.Латви	107.7	165.3	153.5	0.0356	0.0458
17.Литви	30.7	36.9	120.2	0.0102	0.0102
19.Нидерланд	1041	1028.2	98.8	0.3445	0.2849
20.Норвеги	566.7	228.2	40.3	0.1876	0.0632
21.Польш	1704.9	3539.5	207.6	0.5643	0.9806
23.Румын	6.3	13.1	207.9	0.0021	0.0036
24.ОХУ	105583	116803	110.6	34.9454	32.3605
25.Словак	28.2	86.4	306.4	0.0093	0.0239
26.Испани	8.9	5597	62887.6	0.0029	1.5507
27.Швед	634.4	627	98.8	0.2100	0.1737
28.Швейцари	1708.1	3079.1	180.3	0.5653	0.8531
29.Украйн	1040.6	3302.4	317.4	0.3444	0.9149
30.Их Британи	847.1	1439.6	169.9	0.2804	0.3988
33. Хятад	61965	74896	120.9	20.5089	20.7501
34. Кипр	34.7	10.3	29.7	0.0115	0.0029
35. Гүрж	248.1	258.4	104.2	0.0821	0.0716
36. Хонконг	12516.3	10746.1	85.9	4.1426	2.9772
37. Энэтхэг	625.7	558.5	89.3	0.2071	0.1547
38. Индонез	881.5	1049.2	119	0.2918	0.2907
39. Израиль	110.2	619.4	562.1	0.0365	0.1716
40. Япон	18648.6	36656.3	196.6	6.1722	10.1557
41. Казахстан	6104.9	1337.6	21.9	2.0206	0.3706
42. Киргизстан	439.3	420.2	95.7	0.1454	0.1164
44. Өмнөд Солонгос	37345.7	29077.1	77.9	12.3605	8.0559
45. Малайз	1563.2	1570.9	100.5	0.5174	0.4352
46. Пакистан	0	0	0	0.0000	0.0000
47. Филиппин	55.1	93.6	169.9	0.0182	0.0259
48. Сингапур	5146.5	4159.7	80.8	1.7034	1.1525
49. Тайван	1249.4	998.7	79.9	0.4135	0.2767
50. Тайланд	235.5	683.9	290.4	0.0779	0.1895
51. Турк	358.1	519	144.9	0.1185	0.1438

53. Узбекистан	44.2	28.9	65.4	0.0146	0.0080
54. Вьетнам	807.7	805.4	99.7	0.2673	0.2231
57. Бразил	516.8	66.8	12.9	0.1710	0.0185
58. Канад	606.7	1804.1	297.4	0.2008	0.4998
59. АНУ	13056.5	8729.5	66.9	4.3214	2.4185
60. Австрали	1619	9054.1	559.2	0.5358	2.5085
61. Шинэ Зеланд	570.8	825.4	144.6	0.1889	0.2287
Нийт дүн	302137	360943	119.5	100.00	100.00

Гол импортлогч орнуудыг графикаар харуулбал:



Импортын барааны тоо, үнийн судалгаа, мян. ам. долл

/оны эхний хагас жилийн байдлаар/

Барааны нэр	2001		2002		2003	
	тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ
Төмс ,тонн	13253.1	947.9	16863.2	1352.3	25077.9	2259.9
Алим, лийр, тонн	2401.3	388.9	2606.4	523.5	2862.5	521.3
Ногоон цай, тонн	641.9	241.1	1080.3	369.3	984.4	324.0
Цагаан будаа,	4496.5	1284.2	9580.5	2804.0	2953.0	746.4

ТОНН						
Шар будаа, тонн	1673.9	349.3	1738.4	341.3	2126.5	429.2
Гурил, мян,.тонн	40.3	7634.4	50.8	9019.6	40.3	5676.3
Ургамлын тос, тонн	220.6	112.2	121.6	65.8	20.1	16.0
Элсэн чихэр, тонн	6887.0	2002.0	11943. 4	3624.1	6827.1	1748.0
Хатуу чихэр, тонн	1678.5	1260.0	1954.6	1583.8	2437.1	2016.6
Согтууруулах ундаа, мянган литр	4358.4	2895.6	5609.2	3866.0	6190.6	4346.0
Янжуур тамхи, сая ширхэг	299.0	1880.9	284.0	1878.3	370.0	3211.7
Чулуун нүүрс, мянган тонн	8.3	308.2	0.0	6.4		
Авто бензин, мянган тонн	91.1	22983. 3	99.4	22366. 8	108.3	27391. 3
Дизель түлш, мянган тонн	85.0	24422. 4	77.6	18114. 2	90.0	25145. 6
Цахилгаан эрчим хүч, сая. квт.цаг	82.1	1958.0	105.5	2495.2	81.8	2270.9

Импортолсон барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт /ам. долл/

Барааны нэр	х/н	2001	2002	2003	2002/2001	2003/2002
Төмс	т	71.52	80.19	90.1152	112.1	112.38
Алим, лийр	т	161.95	200.85	182.114	124	90.67
Ногоон цай	т	375.6	341.85	329.134	91	96.28
Цагаан будаа	т	285.6	292.68	252.76	102.5	86.36
Шар будаа	т	208.67	196.33	201.834	94.1	102.80
Гурил	мян. т	189439	177551	140851	93.7	79.33
Ургамлын тос	т	508.61	541.12	796.02	106.4	147.11
Элсэн чихэр	т	290.69	303.44	256.038	104.4	84.38
Хатуу чихэр	т	750.67	810.29	827.459	107.9	102.12
Согтууруулах ундаа	мян, литр	664.37	689.22	702.032	103.7	101.85
Янжуур тамхи	сая.шир	6290.6	6613.7	8680.27	105.1	131.25
Чулуун нүүрс	мян.тн	37133	0	0	0	0.00
Авто бензин	мян.тн	252287	225018	252921	89.2	112.40

Дизель түлш	мян.тн	287322	233430	279396	81.2	119.69
Цахилгаан	сая. кв.ц	23849	23651	27761.6	99.2	117.38

Манай импортоор авч буй барааны нийт нэр төрлөөс ард түмний амьдралд зайлшгүй хэрэгцээтэй, тэдний өдөр тутмын амьдралд хэрэглэгдэж байдаг 15 нэр төрлийг сонгон авч дундаж үнийг тооцон үзэхэд зөвхөн сүүлийн жилийн хугацаанд тэдгээрийн 60 хувийн нь үнэ 2 - 47 хувь хүртэл нэмэгдсэн байна. Энэ нь манай гадаад худалдаа эрхэлж буй компаниуд импортын хямд эх үүсвэр хайх талаар дутагдалтай ажиллаж байгааг харуулахын зэрэгцээ ерөнхийдөө дэлхийн зах зээл дээр үнийн өсөлт илүү хурдацтай явагдаж байгаагийн илэрхийлэл болж байна.

Импортын гол нэрийн барааны тоо хэмжээний болон үнийн индекс /%/

/он бүрийн эхний 6 сарын байдлаар/

2001-VI=100

Барааны нэр	Тоо хэмжээний индекс		Үнийн индекс	
	2002	2003	2002	2003
Төмс .тн	127.24	189.22	112.12	126.00
Алим,лийр тн	108.54	119.21	124.02	112.45
Ногоон цай тн	168.30	153.36	91.01	87.63
Цагаан будаа тн	213.07	65.67	102.48	88.50
Шар будаа тн	103.85	127.04	94.09	96.72
Гурил тн	126.05	100.00	93.72	74.35
Ургамлын тос тн	55.12	9.11	106.39	156.51
Элсэн чихэр тн	173.42	99.13	104.39	88.08
Хатуу чихэр тн	116.45	145.20	107.94	110.23
Согтууруулах ундаа мян, л	128.70	142.04	103.74	105.67
Янжуур тамхи сая.шир	94.98	123.75	105.14	137.99
Чулуун нүүрс мян. тн	0.00	0.00	0.00	0.00

Авто бензин мян. тн	109.11	118.88	89.19	100.25
Дизель түлш мян. тн	91.29	105.88	81.24	97.24
Эрчим хүч сая. квт.цаг	128.50	99.63	99.17	116.41

Импортын гол нэрийн барааны тоо хэмжээний болон үнийн индексийг 2001 оны 6-р сарын үзүүлэлтээр суурь болгон тооцож үзэхэд хүнсний ихэнх барааны тоо хэмжээний индекс өссөн байна. Энэ нь нэг талаас зах зээлийг өргөн хэрэглээний бараагаар хангах үйл ажиллагаанд ахиц гарч байгаа мэт харагдах боловч манай зах зээл гадаад зах зээлээс улам бүр илүү хамааралтай болж байгааг гэрчилж байгаа үзүүлэлт юм. Дотоод нөөц бололцоогоо маш муу дайчлан ажиллаж байгаагийн тод илэрхийлэл нь төмсний импорт 2001 оны мөн үетэй харьцуулахад 89 хувь өссөн явдал юм.

5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифийн индекс

/оны эхний 6 сарын байдлаар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар/

	2002	2003
Хүнсний бараа	95.4	110.3
Хувцас гутал	101.4	100.6
Орон сууц, түлш, цахилгаан	109.6	102. 2
Гэр ахуйн бараа	101.0	98.0
Эм тариа	102.5	109.2
Тээвэр холбооны үйлчилгээ	103.2	101. 1
Соёлын бараа үйлчилгээ	98.6	109.0
Бусад бараа үйлчилгээ	102.1	112.7
Ерөнхий индекс	98.9	106.6

Хүн амын амьжиргааны өртгийг тодорхойлох гол хэрэгсэл нь “Хэрэглээний үнийн индекс болдог. Хэрэглээний үнийн индекс нь хэрэглээний дээрх бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ, үйлчилгээний тариф тооцож буй хугацаанд дунджаар хэрхэн өөрчлөгдсөнийг харуулна. Тухайлбал, 2003 оны эхний хагас жилийн

байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тариф дунджаар 6.6 хувь өссөний дотор гэр ахуйн барааны үнэ 2.0 хувь буурч бусад бүх бүлгийн барааны үнэ 1 – 12 хувь өссөн байна.

Экспортын барааны тоо, үнэ, мян. ам. долл

/оны эхний 6 сарын байдлаар/

Барааны нэр	2001		2002		2003	
	тоо	үнэ	тоо	үнэ	тоо	үнэ
Зэсийн баяжмал, мян.тн	285.1	89386.8	258.1	64494.6	232.4	63923.4
Молибдений баяжмал, мян.тн	1.7	2759.1	1.6	2937.4	1.4	4208.6
Ямааны самнасан ноолуур, тн	52.0	4726.2	264.3	13240.8	162.4	7473.6
Хонины арьс, мян. ш	82.7	476.8	279.2	2074.2	4.4	30.9
Ямааны арьс, мян. ш	29.8	178.8	53.9	272.8	11.3	56.5
Үхрийн шир, мян. ш	14.1	250.9	29.7	524.4	12.8	239.2
Хонины самнаагүй ноос, тн	1231.7	781.7	2792.0	2085.1	1429.1	880.3
Тэмээний ноос, тн	94.3	200.8	117.0	235.0	19.7	38.9
Үхрийн хөлдүү мах, тн	3123.0	3064.9	5860.7	5167.1	3168.2	2991.6
Өлөн гэдэс, мян. гогцоо	99.7	1226.9	98.6	1369.3	67.9	1174.0
Жоншны баяжмал	60.9	6000.1	51.4	4739.4	34.7	2977.2

Экспортлосон барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт

/ам. долл/

Барааны нэр	2001	2002	2003	2003 /2001	2003 /2002
Зэсийн баяжмал, мян.тн	313527.88	249882.22	275057.66	87.73	110.07
Молибдений баяжмал мян.тн	1623000.0	1835875	3006142.9	185.22	163.74

Ямааны самнасан ноолуур, тн	90888.46	50097.62	46019.704	50.63	91.86
Хонины арьс, мян. ш	5765.42	7429.08	7022.7273	121.81	94.53
Ямааны арьс, мян. ш	6000.00	5061.22	5000	83.33	98.79
Үхрийн шир мян. ш	17794.33	17656.57	18687.5	105.02	105.84
Хонины самнаагүй ноос, тн	634.65	746.81	615.98209	97.06	82.48
Тэмээний ноос, тн	2129.37	2008.55	1974.6193	92.73	98.31
Үхрийн хөлдүү мах	981.40	881.65	944.25857	96.22	107.10
мян. гогцоо	12305.92	13887.42	17290.133	140.50	124.50
Жоншны баяжмал, мян.тн	98523.81	92206.23	85798.271	87.08	93.05

**Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний
үнийн болон тоо хэмжээний индекс /%/**
/оны эхний 6 сарын байдлаар/

2001-VI=100

		Тоо хэмжээний индекс		Үнийн индекс	
		2002	2003	2002	2003
1	Зэсийн баяжмал, мян.тн	90.53	81.52	79.70	87.73
2	Молибдений баяжмал, мян.тн	94.12	82.35	113.12	185.22
3	Ямааны самнасан ноолуур, тн	508.27	312.31	55.12	50.63
4	Хонины арьс, мян. ш	337.61	5.32	128.86	121.81
5	Ямааны арьс, мян.н	180.87	37.92	84.35	83.33
6	Үхрийн шир, мян. ш	210.64	90.78	99.23	105.02
7	Хонины самнаагүй ноос, тн	226.68	116.03	117.67	97.06
8	Тэмээний ноос, тн	124.07	20.89	94.33	92.73
9	Үхрийн хөлдүү мах, тн	187.66	101.45	89.84	96.22
10	Өлөн гэдэс, мян. гогцоо	98.90	68.10	112.85	140.50

11	Жоншны баяжмал, мян. т	84.40	56.98	93.59	87.08
----	------------------------	-------	-------	-------	-------

Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний тоо хэмжээний болон үнийн индексийг тооцож үзлээ. Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын экспортын тоо хэмжээний индексийг 2001 оны эхний хагас жилийн хэмжээг суурь болгон тооцож үзэхэд 2002 онд 9.5 хувь, 2003 онд 18.48 хувиар тус тус буурсан байна. Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ ихээхэн унаж байгаатай холбоотойгоор манай зэсийн баяжмалын экспортын үнэ ч 2003 оны эхний хагас жилд суурь оны үзүүлэлтээс 12.3 хувь буурсан байна. Манай экспортын гол нэр төрөлд багтах бусад бүтээгдэхүүний хувьд ч байдал ойролцоо байгаа нь ажиглагдаж байна. Харин молибдений баяжмалын экспортын үнэ 2001 онтой харьцуулахад 85,2 хувь, бог малын өлөн гэдэсний экспортын үнэ суурь онтой харьцуулахад 40,5 хувь, хонины арьсны хувьд 21,8 хувь нэмэгдсэн нь экспортын шаардлага хангах түвшинд боловсруулж, түншээ зөв сонгох, дэлхийн зах зээлийн үнийн хувьд харьцангуй тогтвортой байдлыг ашиглах талаар мэдэгдэхүйц ахиц гаргаж чадсаныг харуулж байна.

7. Гадаад худалдааны ерөнхий төлөв ба Гадаад валютын ханш

2003 оны 6 сарын байдлаар 1 ам. долларын төгрөгтэй харьцах ханш өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар өссөн байна. Ерөнхийд нь авч үзвэл 2003 оны эхний хагас жилийн турш ам. долларын ханш аажим өсөх хандлагатай байлаа. Энэ нь 2003 оныг “Монголд зочилох жил” болгон зарласан боловч “SARS” гарсантай холбоотойгоор жуулчид санасан хэмжээнд ирэх магадлал бага байсантай холбоотой байх боломжтой.

US долларын төгрөгтэй харьцах ханш

Сар	Ам. долларын төгрөгтэй харьцах ханш			Өсөлтийн хувь (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар)	
	2001	2002	2003	2002	2003
1	1103	1104	1129	100.1	102.3
2	1103	1104	1132	100.1	102.5
3	1100	1104	1138	100.4	103.1
4	1093	1104	1140	101.0	103.3
5	1100	1102	1130	100.2	102.5
6	1100	1105	1140	100.5	103.2

7.2. Гаалийн татвар

7.2.1. Импортын гаалийн албан татвар

2002 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш импортын гаалийн татварын хэмжээ тогтвортой (5 хувь) төвшинд мөрдөгдөж байна.

Өнөөгийн байдлаар импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ ямар байгааг авч үзье. Үүнд:

- I. Импортын гаалийн албан татвараас дараах нэр төрлийн барааг чөлөөлсөн байна.
 - ◇ Цэвэр үүлдрийн үржлийн адуу
 - ◇ Цэвэр үүлдрийн үржлийн үхэр
 - ◇ Цэвэр үүлдрийн үржлийн гахай
 - ◇ Хонь, ямаа
 - ◇ Мэдээлэл боловсруулах автомат машин ба түүний бүрдэл хэсэг, соронзон буюу оптик уншигч, мэдээлэлийг код хэлбэрт оруулан бичих машин болон бусад газар заагдаагүй мэдээлэл боловсруулах машин тэдгээрийн эд анги, тоног хэрэгсэл
 - ◇ Диод, транзистор ба тэдгээртэй ижил төстэй хагас

дамжуулагч, гэрэлд мэдрэмтгий хагас дамжуулагч, модульд оруулсан буюу оруулаагүй фотогальваник элемент, гэрлийн эмиссийн диод, угсрагдсан пьезо-цахилгаан талст

- ◇ Цахим интеграл схем болон цахим микросхем
- ◇ Эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг ба мал эмнэлэгийн зориулалттай багаж хэрэгсэл, цацраг хэмжих, бүртгэх багаж ба эмнэлгийн бусад эрдэм шинжилгээ туршилтын цахилгаан төхөөрөмж ба хараа шалгах хэрэгсэл
- ◇ Хүн эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг буюу мал эмнэлэгийн зориулалттай буюу зориулалтгүй, рентген туяа, альфа, бета, гамма цацрагийн аппарат, рентген хоолой, рентген үүсгүүр, хянах, тохируулах самбар, үзлэг, эмчилгээний ширээ, сандал, дэлгэц зэрэг хэрэгсэл

II. Дараах нэр төрлийн барааг улсын хилээр оруулахыг хориглосон байна.

- ◇ 80% буюу түүнээс дээш хатуулагтай этилийн хувилаагүй спирт
- ◇ Этилийн хувилсан спирт ба бусад спирт

III. Дараах нэр төрлийн барааны хувьд жил бүрийн 8 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл 15%, бусад улиралд 7%-ийн татвар ногдуулахаар заасан байна.

- ◇ Төмс
- ◇ Сонгино
- ◇ Байцаа
- ◇ Шар лууван
- ◇ Шар манжин
- ◇ Гурил

IV. Дээр дурьдсан болон онцгой албан татвар ногдуулахаар зааснаас бусад бүх бараанд 7%-ийн импортын гаалийн татварыг ногдуулж байна.

7.2.2. Онцгой албан татвар

1. 1997 онд УИХ – ын баталсан Монгол улсын онцгой албан татварын хуулийн өөрчлөлтөөр импортоор орж ирж байгаа суудлын автомашинд түүний хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж, үйлдвэрлэгдсэн оноос хамааран есөн ялгавартайгаар 500 – 6000 ам. долларын татвар ноогдуулахаар тогтоосон билээ.

Энэ тогтоолоор автомашины гаалийн татвар дараах байдлаар тогтоогдсон байсан юм.

Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж (см)	Үйлдвэрлэгдсэнээс хойшхи хугацаа (жил)	Ноогдох татвар (ам.доллар)
2000	0 – 2	500
	2 – 4	1000
	4 - өөс дээш	2000
2001 – 3000	0 – 2	1000
	2 – 4	2000
	4 - өөс дээш	4000
3001 – ээс дээш	0 – 2	1500
	2 – 4	3000
	4 - өөс дээш	6000

Харин 1999 онд Монгол улсын их хурлын 27 дугаар тогтоолоор “Онцгой албан татварын хууль” – д нэмэлт өөрчлөлт оруулж импортоор орж ирж байгаа автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзахгүйгээр зөвхөн ашигласан жилийг нь харгалзан гаалийн татварыг бууруулж тогтоосон байна.

Үүнд:

Үйлдвэрлэгдснээс хойшхи жилийн тоо	Гаалийн татварын хэмжээ (ам. доллар)
0 – 3 жил	500
3 – 10 жил	1000
10 – аас дээш жил	2000

2. 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн монгол улсын их хурлын 51 дүгээр тотоолоор “Онцгой албан татварын хууль”-д өөрчлөлт оруулж өнөөгийн байдлаар онцгой албан татварын дараах хувь, хэмжээ мөрдөгдөж байна. Үүнд:

- ◇ Бүх төрлийн дарсны литр тутмаас 0.75 доллар
- ◇ 40 хүртэл хувийн хатуулагтай бүх төрлийн согтууруулах ундааны литр тутмаас 5.00 доллар
- ◇ 40%-иас дээш хатуулагтай бүх төрлийн согтууруулах ундааны литр тутмаас 6.00 доллар
- ◇ Шар айрагны литр тутмаас 0.20 доллар
- ◇ Бүх төрлийн янжуур болон бусад тамхины 100 ширхэг тутмаас 0.30 доллар
- ◇ Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины кг тутмаас 0.15 доллар

Мөн автобензин, дизелийн түлшний хувьд онцгой албан татварын дараах хэмжээг мөрдөж байна.

(тонн тутамд ам. доллараар)

Хилийн боомт	Автобензин		Дизелийн түлш
	Октаны хэмжээ 90 хүртэл	Октаны хэмжээ 90-ээс дээш	
Цагааннуур, Ярант, Бургастай, Тэс, Гашуун Сухайт	11	12	15
Ханх	17	21	19
Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав	38	43	48

7.2.3. Экспортын гаалийн татвар

I. Хаягдал хар ба өнгөт төмөрлөгийн экспортын гаалийн татвар

	Барааны нэр	Гаалийн татварын хэмжээ (кг тутмаас төгрөгөөр)
1.	Хар төмөрлөгийн өөдөс, хаягдал, дахин хайлуулах төмөр буюу гангийн өөдсийн цутгамал	140
2.	Ширэмний өөдөс, хаягдал	140
3.	Чанаржуулсан , зэвэрдэггүй гангийн өөдөс, хаягдал	140
4.	Хаягдал төмөр зам	140
5.	Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр, чанаржуулаагүй ган	140
6.	Цутгамал, анхдагч хэлбэрт байгаа чанаржуулсан бусад ган, чанаржуулсан бусад гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн	140
7.	Өрөмдөлт, цөмлөлт, боловсруулалт хийсэн болон хийгээгүй эсхүл угсрагдах эд ангиас	140

	бүрдэх төмөр, ган хуудсан материалаар хийсэн шон, төмөр, гангаар хийсэн гагнамал булан хэлбэрт болон сортын төмөр	
8.	Зам төмөр	140
9.	Зэс, цайрын хайлш (гууль)	128
10.	Зэсийн өөдөс, хаягдал	1500
11.	Зэс цулдан, туйван болон огтолбор	1500
12.	Боловсруулаагүй хөнгөн цагаан	450
13.	Хөнгөн цагааны өөдөс, хаягдал	450
14.	Хөнгөн цагаан цулдан, туйван болон огтолбор	350

II. Мал аж ахуйн гаралтай зарим түүхий эдийн экспортын гаалийн татвар

(төгрөгөөр)

	Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ
1.	Тэмээний боловсруулаагүй ноос /эр/	кг	100
2.	Тэмээний боловсруулаагүй ноос /эм/	кг	200
3.	Ямааны боловсруулаагүй /бохир/ ноолуур	кг	4000
4.	Ямаа, ишигний боловсруулаагүй арьс	ширхэг	1500

III. Мод, зүсмэл материалын экспортын гаалийн татвар

	Барааны нэр	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ /төгрөг/
1.	Бөөрөнхий мод, гуалин	шоо метр	150000
2.	Дүнз	шоо метр	150000
3.	Зүсмэл материал	шоо метр	150000